

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг

XXXVIII (412)

2014

(91-98)

Бэлгэ тэмдэг, хээ угалз, зүйрлэл:
“аз жаргалын” тухай монгол зохицол, нийцлийн зарчим

Инес Штольпе

Герман хэлнээс орчуулсан: Сэндэржавын Алимаа (Bonn)

Аз жаргалыг хүсэмжлэх, эрэлхийлэх нь хүн төрөлхтний нийтлэг араншин хэдий ч аз жаргалыг илтгэх бэлгэ тэмдэг нь ертөнц даяар янз бүрийн хэлбэрээр түгэн тархжээ. Аз жаргалыг дотор нь маш олон төрлөөр ангилж болдгийн адил түүнийг илэрхийлэхүйц тодорхойлолт мөн л өргөн хүрээтэй байх нь зүйн хэрэг: хоромхон зуурын хязгааргүй их жаргалаас эхлээд болзошгүй гай зовлонгоос зайлж чадсаны дараах сэтгэл тайвшрал, азтай учрал тохиосны баяр хөөр, сэтгэл хангалуун байдалд суурилсан жаргалтай төлөвийн зэрэгцээ аз жаргалыг эрэлхийлэх элдэв биелэгдэшгүй хүсэл мөрөөдөл ч үүнд багтана. Аз жаргалын тухай хувь хүн болон нийт хамт олны төсөөлөл нь аливаа соёлын салаа мөчир бүрт эрс ялгаатай хэлбэрээр илрэн, цаг хугацааны явцад хүний амьдралын турш өөрчлөгддөг үзэгдэл боловч мөн л энэ ертөнцийн нийтлэг зүйл юм. Тухайн цаг үеийн гол үзэл санааг илтгэгч энэхүү онцгой үзэгдлээс нийгмийн эрэлт хэрэгцээ болон шинжлэх ухааны суурь үзлийн өөрчлөлтийг шууд харах боломжтой байдаг нь аз жаргалын талаарх судалгаа аль хэдийн үндэстэн дамнасан шинж төрхтэй болж, аз жаргал бүрэлдэх нөхцөл байдлыг ч, хүний сэтгэлийн дотоод байр суурийг ч маш амжилттай судалсаар байгаатай холбоотой билээ. Эмпирик судалгаанд оролцогчдоос тэднийг хир зэрэг аз жаргалтай байгааг буюу эн тэргүүнд амьдралынх нь чанарын талаар сонирхон асуудаг. Сүүлийн жилүүдэд *Gross National Happiness* (Bruttonationalglück)¹⁰⁴ буюу “Дотоод дахь нийтийн аз жаргал” хэмээх ойлголт олны танил болсон билээ. Анх 1970-аад онд Бутан улсын хаан Жигме Сингие Вангчук сонгон хэрэглэсэн энэ ухагдахууныг өсөлт хөгжлийн хэвшмэл загвараас ондоо хувилбар хэмээн авч үзэх боломжтой. Үүгээр дамжуулан шударга ёс, тэгш эрх, соёлын үнэт зүйлсийг дэмжин хөгжүүлэх болон тогтвортой хөгжил зэрэг амьдралын чанарын талаарх илүү өргөн агуулга бүхий хэтийн төлөвт анхаарал хандуулсан хөгжлийн өргөн хүрээтэй үлгэр жишээ загварыг бий болгохыг эрмэлздэг учир бусад улс орон ч энэ концептийг хуулбарлан авсан юм. Харин уг ухагдахуун аз жаргалын талаарх Монголчуудын хамгийн түгээмэл бөгөөд олон талт бэлгэдэлтэй юугаараа төстэй болох, түүний олон ургальч шинж чанар яагаад аливаа уялдаа холбоог хөгжил хөдөлгөөнд нь илэрхийлэх боломж олгодог зэрэг асуудалд энэ өгүүлэл анхаарлаа хандуулах болно.

¹⁰⁴ Герман хэлнээ *Bruttonationalglück* (үгчилбэл: *дотоодын үндэсний ба нийтлэг аз жаргал*), сүүлдээ *Bruttosozialglück* (*дотоодын нийгмийн аз жаргал*) буюу *Bruttoinlandsglück* (*дотоодын нийт аз жаргал*) хэмээн орчуулагджээ.

Монгол хэлнээ аз жаргалыг илтгэх, түүний тухай өгүүлэх ухагдахуунууд хоорондоо маш ялгаатай. Тэдгээрийг нарийн шинжлэн тайлбарлавал нилээд томоохон өгүүлэл бичих хэрэгтэй бөгөөд тэгээд ч энд бид ийм зорилгыг тавиагүй билээ. Гагцхүү дараах зүйлийг дурьдахад: герман хэлэнд “аз жаргал” (Glück) хэмээх ерөнхий нэрээр энэ ойлголтод хамаарагдах бүхий л ухагдахууныг нэгэн хүрээнд нэгтгэдэг байхад “Аз жаргал гэж юу вэ?”, “Та аз жаргалтай байна уу?” хэмээх нээлттэй боловч ерөнхийлсөн асуултуудыг монгол хэлэнд шууд л хэдхэн үгээр орчуулах боломжгүй. Учир нь үүний тулд аз жаргалыг илтгэх олон тооны ухагдахуунаас сонгох, улмаар хариултыг сонсогчийн буюу уншигчийн сэтгэлзүйд нөлөөлөх замаар (бусад боломжийн хариултаас холдуулан) тодорхой чиглэлд хандуулахаас өөр аргагүй болно.

Харин аз жаргалыг бэлгэдэх бэлгэдлийн ертөнцөд байдал өөр: аз жаргалыг илтгэх дээрх герман ухагдахуунтай жишихүйц, “аз жаргал” хэмээх том ойлголтыг маш өргөн утгаар *pars pro toto* буюу тодорхой хэмжээгээр төлөөлөхүйц нэгэн бэлгэдэл монгол соёлд байдаг нь энх жаргалангийн төгөлдөр бэлгэдэлт ханан хээ юм. Хэдийгээр аз жаргалыг нэрлэх боломжтой олон нэршил дундаас *өлзий* хэмээх үг зүйрлэлийн хэллэгт ч газар усны хийгээд оноосон нэрээр зогсохгүй хүний нийлмэл нэрийн бүтцэд ч элбэг тохиолдох зэргээр нилээд түгээмэл хэрэглэгддэг ч энэ бэлгэдэл мөнхөд оршин нүднээ үзэгдэх хэлбэрээрээ бүр тод томруун илэрч байдаг: монгол гэрийн бүрээс юмуу үүдэн дээр, гэрийн тавилга, мал аж ахуйн тоног хэрэгсэл, барилга байшин түүний орох хаалга, шуудангийн марк, хувцас хунар, хөөрөгний даалин юмуу гар утасны гэр дээр эсвэл бүр товч, ээмэг, малын им тамга, эмээлийн гөлөм дээрх хээ угалз, машины арын толинд зүүсэн сахиус гэх зэргээр *өлзий* хээг монгол хүний амьдралаас салгаж төсөөлөхийн аргагүй байдаг. Учир нь *өлзий* бол сайн сайхны бэлгэ тэмдэг, бүх юм сэтгэлийн аяар, санаснаар, бүрэн төгс бүтэх утгыг агуулдаг аз жаргалын монгол бэлгэдлийн хамгийн чухал бөгөөд өргөн утга санаа бүхий бэлгэ тэмдэг мөн. Тиймээс ч түүнийг Эрика, Манфред Таубе нар (Германы монгол судлаачид, орч.) „seine Verwendung kommt einem Segen gleich “буюу утгачлан хөрвүүлбэл “түүнийг „([монголчууд], орч.) эгээ л бурхнаас заяасан буян хишигтэй адил дээдлэн хэрэглэдэг” (Erika Taybe&Manfred Taybe 1983: 251-р тал) хэмээн тэмдэглэсэн байдаг.

Өлзий хээний хамрах хүрээ 20-р зуунд Монголд гаднаас оруулж ирсэн жишээлбэл (зөвлөлтний) таван хошуу од шиг олон янзын бэлгэ тэмдэгтэй харьцуулахад хавьгүй өргөн юм. Социалист Монголд таван хошууг тухайн улсад угаас байдаг ч өнөөг хүртэл яг оноосон дүрс тэмдэггүй байсан агуулгын концептийг үзүүлэн таниулж буй зүйл мэтээр ухуулан тайлбарладаг байжээ. Монгол Улсын бэлчээрийн таван төрлийн малыг нэрлэх “таван хошуу мал” хэмээх хэлцэд агуулагддаг *таван хошуу* энэхүү одны хэлбэртэй давхацдаг нь таван хошууг олонд танил болоход шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсний дээр уг тайлалыг логик үндэслэлтэй болгодог байв (Штольпе, 2006). Ямар нэг зүйлийг төлөөлөн нэрлэдэг нэршлийн олон салбар утгат шинж чанарыг Рожер Чартиер (1989) (гагцхүү танин мэдэхүйд суурилан тодорхой болдог) *intelligible Zeichen* буюу *танин мэдэх боломжтой тэмдгийн* онолдоо судлан бичсэн байдаг. Аливаа бэлгэ тэмдгийг хүн амьдрал ахуйдаа хэрэглэн байж, дотоод сэтгэл ба гадаад бодот байдал өөрөөр хэлбэл төсөөлөл ба дүрслэл хоорондоо ямар харьцаанд оршиж, бие биедээ зохицдог нь тодорхой болно. Концептүүдийг холбогч процесс байнгын хувирал хөдөлгөөнд оршино. Тэгвэл дээрх үйл ажиллагаа ийм хувирал хөдөлгөөнд үндэслэн явагддаг байна. Хэрэв өлзий хээний олон салбар утгат шинж чанарыг нарийвчлан авч

үзвэл уг хээ хийсвэр утгаараа янз бүрийн концептийг хооронд нь холбосноороо жишээлбэл аз жаргалын талаарх монгол зохицол нийцлийн зарчмыг хэрхэн илэрхийлэх боломжтой нь тодорхой болно.

Монгол бэлгэдэлзүйн орчин үеийн дэлхийн хамгийн нэрт судлаач Сэндэнжавын Дулам монгол бэлгэдэлзүйн өөрийн бүтээлүүд түүний дотор дөрвөн боть нэвтэрхий толиндоо бэлгэдлийн элементүүд зөвхөн уялдаа холбоогоороо дамжуулан биеллээ олдог олон утгыг илтгэсэн бүхэл тогтолцоонуудын ямагт нэг хэсэг байдгийг¹⁰⁵ судлан, зэгсэн олон жишээгээр тайлан тайлбарласан билээ. Бэлгэдлийн нэгжүүд нь харилцан бие биетэйгээ холбогдсон байдгийг аз жаргалын өлзий хээнээс өөр ямар ч бэлгэдэл ингэж ил тод илтгэдэггүй. Үүнийг Дулам амьдралын олон талт цогц мэдлэг туршлагын кодчиллол, улмаар монголын бэлгэдлийн цөм-тэмдэглэгээ, дүрс, бүр нийгмийн үйл явцын „амин сүнс“ хэмээн нэрлэж байна (Дулам 2009: 23). Утгазүйн хувьд энэхүү тэмдэг (*хутаг урт буюу өлзий хутаг орших* гэсэн утгатай) тогтвортой аз жаргалтай байдал төлөвийг илэрхийлж, (*аливаа сайныг ирүүлэх хувь хүчин*)¹⁰⁶ сайн сайхан үйлийг бий болгох чадвартай нь хэн бүхэнд илэрхий болно.

Дуламын бодлоор *цлјеi* (монгол бичгийн бичлэг) үгийн утга ан авын уламжлалаас үүдэлтэй: анчид анд мордон зүтгэж, олз омогтой (*olja*) байхын дээр ойрд-монгол аман аялгуунд *olja* гэхийг *цлје* гэж дууддаг байна. Ийнхүү аз, олз хоёрыг холбосноос гадна ан авын „*олз оруулагч зангилаа*“ нэртэй нэгэн уламжлал байжээ: анчид дээлийн бүсэндээ хоёр газар зангилаа гарган, дараа өдрийн ан авандаа олз омог урин дуудаж, дэрнийхээ хажууд тавиад унтдаг байжээ. Хожим нь *өлзийн* утга ан авын практикт хэрэглэгдэхээ больж, өргөн агуулгаараа аз жаргалыг илтгэхдээ *сэтгэлийн амар амгалан* гэсэн санааг багтаадаг болсон тухай Дулам бичсэн байна. Үүнийг нотлох гүн агуулгатай жишээ бол угийн аюултай араатан амьтан үүр агуйдаа тайван байдгийг илэрхийлсэн “чоно үүрэндээ өлзийтэй” хэмээх хэлц юм. Мөн *олз* (орлого, олз олох, ашиг тус, олз ашиг)¹⁰⁷ ба *өлзий* (аз жаргал, амар мэнд сайн сайхан байдал) хоёрын холбоотой шинжийг орчин цагийн хэлэнд ч тодруулах боломжтой хэвээр байна: энэ хоёрыг хоёуланг зүйрлэл хэлбэрээр хэрэглэх боловч холбон хослуулж хэлэхэд *өлзий* нь илүү хийсвэр ухагдахуун болдог (Дулам 2009: 23-25). Ийнхүү овоо тахих ёсонд овоонд гурван чулуу нэмж, гурав эргэхдээ дараах үгсээр шившдэг билээ (мөн тэнд: 25):

Овооны их нь тандаа
Олзны их нь маньдаа
Өлийн их нь тандаа
Өлзийн их нь маньдаа

¹⁰⁵ Уг нэвтэрхий толь 2011 онд 2 дахь удаагаа хэвлэгдсэн. Тэргүүн ботид тооны, дэд ботид өнгө ба зүг чигийн, гутгаар ботид хэлбэр дүрс болон тэмдгийн (түүний дотор өлзий хээний бэлгэдлийн тухай 129-131-р талд), 4-дэх ботид зүүд ба урьдчилсан таамаглалын болон цаг хугацааны бэлгэдлийн талаар тус тус өгүүлдэг.

¹⁰⁶ Францын угсаатан судлаач Изабел Бианкийн хэлснээр өлзий нь “аливааг хүч /эрх мэдэл /чадвараар (pouvoir) дамжуулан, ивээл (grace) буй болгох адис буян заяа (bénédictio) мөн (Bianquis 2013: 85).

¹⁰⁷ Эдгээр “ол-”, “нээ-”, “илрүүл-” ба “хож-, ашиг тус ол-” зэрэг үг утгын хувьд төстэй, өргөн утгаараа “аливаа олзыг” үүсгэж бий болгодоггүй, харин *олз* угаас оршин байдаг” гэсэн санааг давхар агуулж байна. Ингэхлээр хам сэдэв ямар нэгэн үйл явцын дохио тэмдэг болж байвал “олох үйл” гэсэн үгээр герман хэлнээ буулгах боломжтойг энэхүү өгүүллийг бичигч дурьдсан байна.

Ийнхүү бид аз жаргалыг илтгэх концептүүдийн хоорондын уялдаа холбоог цаг үетэйгээ холбон шинэчилдэг бэлгэ тэмдгийн харилцан үйлчлэлийн зүйрлэлийн талаар нар зөв зам хазайн өгүүлсэн энэ бяцхан аяллынхаа дараа энэхүү бэлэг тэмдгийн нүдэнд харагдах төлөөллийн хэлбэрүүд рүү эргэн оръё. Дулам энэ тухайд нэмж өгүүлэхдээ: уяа ашиглан өлзий зангидахдаа ч, аз жаргалын зангилаа өлзий хээг зурахдаа ч тасралтгүй нэг амьсгаагаар үйлдэх нь хамгийн чухал байдаг агаад энэ нь өлзийт зангиас үл тасалдах, нэгэн санаа, нийтлэг сэтгэл, сайн сайхны дээд бэлгэдэл чанарыг агуулдагтай холбоотой. Ингэж бүтээсэн өлзий хээ бүхий мотивууд хоёроос арван гурав хүртэл - ховор боловч тавь хүртэл - (монголоор: *нүд хэмээнэ*) тооны гогцоотой, харин муу ёрын тоо гэгдэх долоо үүнд ордоггүй. Монголчуудын соёлын хүрээнд арван гогцоотой өлзий буюу *арван нүдэн өлзий* хамгийн их тархсан нь нэг ёсондоо бэлгэдэл төгөлдөр хувилбар дүрс *өлзий зангиа* юм. Эдгээр нь онцгой намуун төвшин, эв зохицлын үйлчлэлтэй бөгөөд хүч чадлыг төгс байдлаар холбогч нэгдэл, бат холбоог бэлгэддэг байна. Иймээс арван нүдэн өлзий хээ таван нүдэн өлзийн адил монгол гэрийн үүд болон авдрын нүүрэн талын чимэг хэлбэрээр маш элбэг тохиолддог билээ. Мөн монгол гэрийн ханын завсрын ромбо буюу адил талт жишүү дөрвөлжин хэлбэрийн зайг өлзий хээний нүд гэж үзэх боломжтой. Үүнээс уламжлан монгол гэрийг босоо чиглэлээр нь ажиглавал: гэрийн үүдний чимгээс эхлээд хээ хуар зурсан авдрууд байрлах арын хоймор хүртэл, ромбо хэлбэрийн галын өр бүхий шалнаас дээш тоонон дээрх эсгий өрх хүртэл өлзий хээгээр дүүрэн байдаг тухай Дулам өгүүлж байна. Зохиогч цааш нь бичихдээ түүнчлэн монгол гэр бүхэнд босоо чиглэлд арван нүдэн өлзий нүдэнд үл үзэгдэх хэлбэрээр байрладаг гэжээ. Энэ нь сансар огторгуйн төсөөллийн хорин дөрвөн гадаад өнцөг бүхий төгс төлөөлөл болж дөрвөн зүг, ээлжлэн ирдэг арван хоёр жил болон найман өнгийг заана¹⁰⁸. Дуламын бодлоор ийм олон янзын бэлгэдлийн зүйлээс улбаалан монголчууд үндэсний гэр дотроо амьдралын олон талт цогц мэдлэг туршлагын зүйрлэл, нийгмийн холбоо харилцаа- сүлжээний төлөөлөл болдог өлзий хээн дунд амьдралаа өнгөрөөдөг байна (мөн тэнд: 27 -31).

Төсөөлөн бодох ба дүрслэн үзүүлэх хоёрыг холбохын тулд аливааг төлөөлөн дүрслэх төлөөлөл олон салаалсан нөөц чадавхитай байх шаардлагатай. Өлзий хээ тэр ч байтугай (Андерсон, 1983)-ы „төсөөлөн бодсон нэгдэл, хамтрал“¹⁰⁹ гэсэн утгаар өргөн хүрээний сүлжээний зүйрлэл хэлбэрт илүү тохирдог нь илэрхий байна. Энэ утгаараа бэлгэдлийн концептүүдийг хооронд нь холбоход ч, социализмын үеийн аливаа үг хэллэгийн цаадах далд утгыг билгийн нүдээр харахад ч тэр аль алинд нь холбоо харилцааны ба соёлын түүхийн хувьд маш сонирхолтой нэгэн тохиолдлыг Клаус Сагастер (1978) герман хэлтэн уншигчдад дэлгэн танилцуулжээ: 1959 онд анх уйгаржин-монгол (монгол) бичгээр хэвлэгдсэн “Энх тайвны бадамлянхуа цэцэг” товхимолд Улаанбаатар дахь Гандан хийдийн хоёр лам¹¹⁰ Буддизмын үзэл санааг дэлхийн энх тайвны хөдөлгөөний үндсэн ойлголтуудад нийцүүлэн тайлбарлахыг оролдсон байна. Үүний тулд тэд аз жаргалтай оршихуй, энх тайван, найрамдал, эв нэгдэл буюу тэгш эрх зэрэг үнэт зүйлийн тухай ойлголтуудыг багтаасан Буддын шашны түгээмэл

¹⁰⁸ Зохих дүрслэл болон бусад тайлбарыг Бианки 2013: 90 - 91-р талд харна уу.

¹⁰⁹ Уг нэр томъёог зүйрлэлийн төрөлд нүүр тулсан харилцаанаас давсан хэмжээтэй, адил төстэй санаа бүхий бүлгүүд хэрэглэхээс өмнө анх Бенедикт Андерсоны (1983) „imagined communities“ -ын герман орчуулгын гарчиг „Erfindung der Nation“ буюу „үндэстэн гэдгийг зохиож бодож олох“ гэдэг нэрээр олонд танил болжээ.

¹¹⁰ Т. Дангзанг-Одсэр ба С. Ишитавхай

бэлгэдлүүдийг судалж, тухайн цаг үед ч ашиглаж болохуйц тэнцүү чанарт зүйлсийг эрж хайн, эрснээ ч олжээ. Энэ хам сэдэвт *өлзий* юуны өмнө ижил нэрт *өлзийт найман тэмдэг* буюу “жаргалын найман тахил”-ын дунд уламжлалт хэлбэрээрээ оршихдоо тухайн бичвэрт “энх тайвны цагаан шүхэр” нэрээр (Сагастер 1978, 465) нийт арван нэгэн бэлгэдлийг нэгтгэн оруулсан байна. Социалист нийгэмд энх тайвныг аливаа аз жаргалын үндсэн нөхцөл, дээд эрэмбэд орших үнэт зүйл хэмээн сурталчилдаг байсан учир дээрх товхимлыг зохиогчид Буддын шашны хувьд ч энэ нь ялгаагүй байдаг гэсэн агуулгыг илэрхийлснээрээ аз жаргалыг магтан дуулж, эв хамт нийгэм, сүсэг бишрэл хоёрыг ухаалгаар холбож өгчээ. Энд бидний анхаарлаа хандуулж буй *өлзий* “*engke tayibung-un öljeitü utasu*” буюу *энх тайвны өлзийт утас*” хэмээн тодорхойлогдож, герман хэлнээ Сагастерын орчуулснаар дараах байдлаар унших боломжтой: (герман орчуулгыг монголоор буулган доор хавсаргав, орч.):

„{...} Гайхамшигт энх тайван, баяр баясгаланг илтгэх аз жаргалын зангилаа,

Даяар орны амьд бүхний итгэл найдварын алтан утаснаас тогтон,

Онцгой соёлын нягт хэлхээ холбооны уран сүлжээгээр зангилагдан,

Зовлон үгүй төгөлдөр аз жаргалын олон үүдийг оршоосон” (мөн тэнд 488-р тал).

Мөн энэхүү товхимолд хавсаргасан “энх тайвны өлзий хутгийг түгээх гэрэл хэмээгч шүлэглэсэн үгийн сүлжээний” бадгуудад (мөн тэнд 492-р тал) *өлзий* хэмээх ухагдахуун *өлзий хутаг мандах болтугай* (мөн тэнд 494 - 496-р тал) болон *өлзий бат мандах* (мөн тэнд 494 - 495-р тал) зэрэг нийлмэл бүтцийн хэлбэрээр илэрч байна. Ийнхүү уг тааврыг нэрлэсэн гэрэл, дүрслэл зүйрлэлийн өргөн боломжийн зэрэгцээ соёлын түүхийн утгыг дээд зэргээр тодруулан харуулж байна:

Цлҗеi qutuу (орчин цагийн монгол хэлээр: *өлзий хутаг*) хэмээх хоршоо үгийг герман хэлнээ ихэвчлэн ‚Glückseligkeit‘ буюу “аз жаргалтай байдал” юмуу ‚Heiligkeit‘ буюу “ариун дагшин төлөв” гэж хөрвүүлэн, аз жаргалын талаарх иж бүрэн ойлголтын оюун санааны болон сүсэг бишрэлийн аспектиг ч мөн зааж байдаг. 1959 онд дээр дурьдсан хоёр ламын туурвисан ийм бүтээл БНМАУ-ын Улсын Хэвлэлийн Газарт хэвлэгдэх хэмжээнд хүрч чадсаныг Цэндийн Дамдинсүрэн, Бямбын Ринчен хэмээх хоёр эрдэмтний санаачилсан ажлын үр дүн гэж үзэх нь зүйтэй: герман уншигчдад зориулан Сагастерын бүрэн хуулга болгон хувилж, орчуулж, тайлбар хийж нийтлүүлсэн энэ бүтээлийн хянан тохиолдуулагчаар лавтайяа ажилласан Дамдинсүрэн мөн тэр жил өгүүллүүдийн эмхэтгэл хэвлүүлж, түүндээ монголын соёлын өвийг үгүйсгэсэн, гүтгэсэн зүйлийг шүүмжлэн бичиж байжээ¹¹¹. Сталины дараах улс төрийн уур амьсгал харьцангуй зөөлөрсөн цаг үед тэрээр Ринчентэй хамтран, монголын эртний уран зохиолыг дахин

¹¹¹ 1955 - 1958 онд бичигдсэн нийт таван өгүүлэл багтсан уг эмхэтгэл “Соёлын өвийг хамгаалъя” гэсэн гарчигтай байжээ.

хэвлэн ард нийтийн хүртээл болгох ажлыг зохион байгуулсан байна (C. R. Bawden 1968: 414-р тал).

Тэгэхлээр аз жаргалын өлзий зангилаа буюу сүлжээ аз жаргалын нийцэл зохицлын зарчим болох боломж хир байна вэ? Энэхүү өгүүлэлдээ бид уншигчдын анхаарлыг аз жаргалын талаарх оюун санаа, сүсэг бишрэлийн аспектад хандуулан, үүнийгээ пан-Буддизмын агуулгатай хамтатган, социализмын үеийнх шиг *мөр хоорондын далд утгыг өлзий* хээний „нүдээр“ дамжуулж ч болов олж харах боломж олгож буй билээ. Энэ бэлгэ тэмдэг бол, Сагастерийн “Энх тайвны цагаан бадамлянхуа цэцэг” товхимлынхоо тайлбарт бичсэнээр Буддаг гэгээрсний дараа бурхдаас түүнд бэлэг болгон өгсөн, хөлийнх нь уланд оршин байсан хэмээх жаргалын найман тахилын нэг мөн. Мөн ижил агуулгаар 1969 онд Бутанд тус улс Дэлхийн Шуудан Холбооны Байгууллагад элссэнтэй холбогдуулан, аз жаргалын дээрх найман тэмдгийн дүрс бүхий шуудангийн марк, хожим нь 1975 онд бэлгэдэл дүрс тус бүрээр шуудангийн тэмдэгт тусдаа хэвлэгдэн гарч байжээ (Сагастер 1978: 502-503). Дээр өгүүлсэн хоёр монгол ламын санаачлан хэрэгжүүлсний адил хил хязгааргүй хэрэглэгдэж буй буддизмын бэлгэ тэмдгүүдийн талаарх ийм төрлийн программын хандлагатай заалтуудыг Аржүн Аппадурайн (1996: 33-р тал) дурьдсантай санал нэгдэн, „ideoscape “буюу аливаа соёлын үзэгдлийн түгэн тархах урсгалын нэг аспект хэмээн ойлгох боломжтой. Аппадурай „ideoscape“-ийг арвин баялаг агуулга бүхий „landscapes of images “(мөн тэнд: 35-р тал) гэж нэрлэдэг:

„These landscapes are the building blocks of what (extending Benedict Anderson) I would like to call imagined worlds, that is, the multiple worlds that are constituted by the historically situated imaginations of persons and groups spread round the globe. “ (мөн тэнд: 33-р тал)

Дэлхийн энх тайвны хөдөлгөөний талаарх энд авч үзсэн тохиолдолтой адил бүтээлч үйл ажиллагааны үр дүнд жаргалын найман тахил түүний дотор *өлзий* хээний илтгэх оюун санааны үнэт зүйлийг дэлхий даяар түгээн таниулах боломжтой юм. Аз жаргалын энэ зангилааг Дулам судлан боловсруулж, амьдралын олон талт туршлага болон нийгмийн харилцааны хэлхээ холбоог төлөөлөх нэг төрлийн ёсзүйн хэм хэмжээс болгон тодорхойлсон нь монгол соёлын хүрээнээс даруй халин, соёлын ба харилцааны түүхийнх нь бусад аспектад бидний анхаарлыг хандуулж буй билээ.

Энэхүү өгүүлэлд хооронд нь уялдуулан авч үзсэн янз бүрийн концептийн бие биетэйгээ олон талаар давхцан нийлж буй шинж дээр тулгуурлан, энэ бэлгэ тэмдэг нь зохицол нийцлийн¹¹² монгол зарчмаар аз жаргалыг илтгэж байна хэмээсэн дүгнэлтийг би санал болгож байна. Илэрхийлэх утга агуулгаараа нийгмийн харилцаанд нөлөөлөх чадамжтай өлзий хээ нь соёлын хуучин ба шинэ өвийн хооронд гүүр болон үйлчлэх, түүнчлэн аль нэг улсын хил хязгаарт баригдахгүйгээр хүмүүс оюун санаа, итгэл үнэмшлийн хувьд нэгдэх хэлхээ холбоог бүрдүүлэхэд түлхэц үзүүлэх боломжтой юм. Зохицол нийцлийн зарчмын хувьд энэ хээ улмаар ялгаатай үзэл баримтлалын зэрэгцэн орших, харилцан үйлчлэх үйлчлэлийг, олон янзын салбарт хүчин төгөлдөр байдаг тогтолцооны хувирагч нэгжийн адил хооронд нь холбох чадвартай. Үүний тулд аз жаргалын аспектүүд дан дангаараа бус, харин бэлгэ тэмдэг, хээ угалз, зүйрлэл болон эдгээрийн бүрэлдэх нөхцөл байдал, дотоод үзэл баримтлал зэргийн хослол нийлэмж

¹¹² Анх квантын онолын ойлголтод хэрэглэгдсэн энэ ухагдахууныг танин мэдэхүйн онолд хуулбарлан авсан бөгөөд үүнээс хойш бие даан хөгжсөн байна.

хэлбэрээр мэдээлэл түгээх учиртай. Эцэст нь өлзий хээг илрэх хэлбэрээр нь уран бүтээлч Сүсе Веберийн „Bildvokabel“¹¹³ буюу “Зураг үг” хэмээн нэрлэсэн утгаар ойлгож болох юм. „Bildvokabel” “нь аливаа бэлгэ тэмдгийн адил олон салаа утгатай учир харилцан ялгаатай орчинд өөр өөр нөхцөл байдалд үйлчлэн, олон янзын холбоо хамаарлыг бий болгодог байна. Чухам энэ шинж монгол бэлгэдлийн өлзий хээнд ч бүрэн оршин буй нь тэрээр дүрс хэлбэрээрээ дамжуулан хэлхээ холбоог үүсгэн бүтээж, зохицол нийцлийн зарчмын хувьд аз жаргалын цогц үлгэр загварыг илэрхийлдэгтэй уялддагийг бид энэ өгүүлээс ойлгож мэдэрсэн билээ.

НОМЗҮЙ

- Anderson, B. (1983): *Imagined Communities*. Brooklyn and London: Verso Books
- Appadurai, A. (1996): *Modernity At Large: Cultural Dimensions of Globalization*. Minneapolis: University of Minnesota Press
- Bawden, C. R. (1968): *The Modern History of Mongolia*. London: Weidenfeld and Nicolson.
- Bianquis, I. (2013): *Mongolie. Une Culture en Mouvement*. Collection ‘Civilisations étrangères’. Presses universitaires François-Rabelais
- Chartier, R. (1989): *Die unvollendete Vergangenheit. Geschichte und die Macht der Weltauslegung*. {Дуусгаагүй өнгөрсөн үе. Ертөнцийн тайлалын түүх ба эрх хүчин}. Berlin: Verlag Klaus Wagenbach
- Дулам, Сэндэнжавын (2009): *Монгол бэлгэдэл зүйн тогтолцоо, түүний чанарыг тайлан унших нь*. {Reading the System and Quality of the Mongol Symbolism}. In: *Study of Mongol Symbolism: Quest and Perspectives*. International Conference, Centre for the Study of Nomadic Civilisations, School of Mongolian Language and Culture, National University: Ulaanbaatar 2009: 14-37
- Дулам, С. (2011): *Монгол бэлгэдэл зүй. Гутгаар дэвтэр: Дүрсийн бэлгэдэл зүй, дохио зангааны бэлгэдэл зүй*. {Mongolische Symbolik. Band III: Symbolik der Figuren und Zeichen / Signale}. Ulaanbaatar: Bitpress
- Sagaster, K. (1978): *Der weiße Lotus des Friedens*. Eine moderne mongolische Interpretation buddhistischer Symbolik. {Энх тайвны цагаан лянхуа. Буддын бэлгэдлийн орчин үеийн монгол тайлал} In: *Zentralasiatische Studien* 12: 464-541
- Stolpe, I. (2006): *Die Mongolisierung des Sowjetsterns*. Ein Beispiel für die Rolle des Zufalls beim Transfer von Symbolen. {Зөвлөлтийн таван хошууг монголчилсон нь. Бэлэг тэмдгийг шилжүүлэн хэрэглэхэд санамсаргүй тохиолдол үүрэг гүйцэтгэдгийн нэг жишээ}. In: *Comparativ. Leipziger Beiträge zur Universalgeschichte und vergleichenden Gesellschaftsforschung*. Special Edition „Locating Transfer“, 30-43
- Taube, E. ; Taube, M. (1983): *Schamanen und Rhapsoden. Die geistige Kultur der alten Mongolei*. {Бөө болон тууль хайлагчид. Эртний Монголын оюуны соёл}. Leipzig: Koehler & Amelang

¹¹³ www.suse-weber.de хаягаар түүний уран бүтээлийг үзэх боломжтой.

SUMMARY

The wish and striving for happiness is a universal human phenomenon. Happiness symbols are prevalent throughout the world, although individual and collective ideas of happiness vary across cultures and time. Lately, happiness research has become trans-national with a focus on structural conditions as well as on attitudes, focussing on aspects of life quality. Especially the concept Gross National Happiness, originally coined by the king of Bhutan, is widely considered an alternative to conventional growth-oriented models, because it includes perspectives such as justice, the promotion of cultural values and sustainability, and therefore strives for a holistic paradigm of development. This essay investigates connections to Mongolia's most universal symbol of happiness, the *uľzij*. Common in metaphorical language and names, the popularity of the *uľzij* is equally evident in its visual omnipresence in all spheres of life. We know that symbolic actions correspond equivalents between inner and outer reality, between imagination and depiction. Relations between concepts are established in dynamic communicative processes. The *uľzij* is a case in point, for what reason I designate it as a Mongolian correspondence principle of happiness. The term correspondence principle, which had travelled from quantum theory into epistemology, serves as an analytical tool to investigate the *uľzij*'s communicative potentials in combining parameters of happiness. Based on S. Dulam's analysis of symbols as systemic elements and his characterisation of the *uľzij* as a codification of a holistic experience, as a core-icon and spirit of social processes, this essay explores symbolic, ornamental and metaphorical potentials. Being a prime example for communicative dynamics of entangled history, we find that the *uľzij* has proved a powerful configuration of ideational values, communicating happiness as a holistic paradigm.